



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: letter@moh.gov.mn, http://moh.gov.mn

2022.04.28 № 1а/1984
танай 2022.04.14-ны № 17 -т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.ТУВААН ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх
тухай

Монгол Улсын Их Хурлын 2014 оны 57 дугаар тогтоолоор “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого” батлагдаж, 2014-2018 оны хооронд хэрэгжих байсан боловч Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого” батлагдаж, хэрэгжүүлэх чиглэлийн “2.3.6.Эм зүйн тусламж, үйлчилгээ” туссан. 2021 онд Үндэсний аудитын газраас “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө”-д гүйцэтгэлийн аудит хийсэн.

Гүйцэтгэлийн аудитын тайлантай холбоотой таны тавьсан асуулгын хүрээнд авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 6 хуудастай.

Хүндэтгэсэн,



С.ЭНХБОЛД

141422494

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ц.ТУВААН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРААС
“ТӨРӨӨС ЭМИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ”-Д
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНТАЙ ХОЛБООТОЙ ЭРҮҮЛ
МЭНДИЙН САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

1. Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, өнчин эмийн үнийн дээд хязгаарыг хэрхэн тогтоож байгаа тухай болон эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.10-т “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох” гэж заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 13 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-г баталсан. Энэхүү тогтоол болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/101 дүгээр тушаалаар Монгол Улсын хүн амын дунд зонхилон тохиолддог өвчин эмгэгийн үед хэрэглэх, олон Улсын эмнэлзүйн удирдамж (UpToDate)-д зөвлөсөн ерөнхий нэршил, тун бүхий 574 нэрийн эмэнд үнийн дүнгээс хамааруулан 30, 50, 70 хувийн хөнгөлөлт олгож байна. Эмийг эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээтэй 1,800 гаруй эмийн сангаар дамжуулан иргэн даатгуулагчид хүргэж байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Ремдесивир, Фавипиравир, Умифеновир зэрэг эм импортлогч 28 байгууллагатай үнийн хэлцэл хийж, нийт 24 үйлдвэрийн, 26 худалдааны нэршил бүхий вирусийн эсрэг эмийн бөөний болон жижиглэнгийн үнийн дээд хэмжээг тогтоож ажилласан. Үүний дүнд үнийг 20-30% бууруулж, хүртээмжийг нэмэгдүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн “Жагсаалт батлах тухай” 132 дугаар тогтоолоор Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед хэрэглэгдэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн бөгөөд энэ хугацаанд 257 аж ахуйн нэгжийн 615 нэр төрлийн 1,1 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис гаалийн 32,6 тэрбум төгрөгийн, нэмэгдсэн өртгийн 68,8 тэрбум төгрөгийн албан татвараас тус тус чөлөөлөгдсөн. Эм, эмнэлгийн хэрэгсэл, түүхий эдийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлснөөр иргэнд очих эм, эмнэлгийн хэрэгслийн үнийг 5 орчим хувиар бууруулдаг.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2020 оны А/102 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг тогтоох аргачлал”-ын 3.1-д “Эрүүл мэндийн даатгалын сангаас эмчилгээнийх нь

эмэнд үнийн хөнгөлөлт үзүүлэх өвчин эмгэгийг сонгохдоо архаг өвчин, хурц өвчин, хүүхэд болон ахмад настанд зонхилон тохиолдох өвчин гэсэн үндсэн 4 бүлгийн дагуу өвчин эмгэгийг сонгох”, 4.1.2-т Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн байх, 4.1.3-т Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад багтсан тарилга болон дуслын шингэнээс бусад эмийн хэлбэрээр байх гэсэн заалтын дагуу хөнгөлөлттэй эмийн жагсаалтад өнчин эм ордоггүй.

Эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нэгдсэн худалдан авалт, жишиг үнийг хэрэгжүүлэх, эмийн үнийн ил тод байдлыг хангах, эмийн үнийн шатлал бүр дэх нэмэгдлийн хэмжээг тогтоох зэрэг зохицуулалтуудыг тусгахаар ажиллаж байна.

2. Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн үнийг бууруулах үүднээс нэгдсэн худалдан авалт болон олон улсын байгууллагаар дамжуулан хийх худалдан авалтыг өргөтгөх, худалдан авах эмийн нэр төрлийн сонголтыг сайжруулах талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашид авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа үйл ажиллагааны тухай:

Эм, эмнэлгийн хэрэгслийн үнийг бууруулах, төсөвт хэмнэлт бий болгох зорилгоор Ерөнхий гэрээгээр худалдан авах буюу цахим дэлгүүрт байршуулах үйл ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтран 2019 оноос эхлэн зохион байгуулж байна.

2021 оны байдлаар цахим дэлгүүрээс 82 нэрийн эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуурт 49.6 тэрбум төгрөгийн худалдан авалт хийгдэж, 12.8 тэрбум төгрөгийн хэмнэлт хийгдсэн байна. Үүнээс 21 нэрийн зайлшгүй шаардлагатай эмэнд 88,7 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна. Ерөнхий гэрээгээр худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг жил бүр нэмэгдүүлж байгаа бөгөөд 2022 онд 34 нэрийн эм, 7 нэрийн эмнэлгийн хэрэгслийг нэмэлтээр оруулахаар Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүсэлт гаргаад байна. Үүнээс Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон 15 нэрийн эм байна.

Зүрх судас, чихрийн шижин, хорт хавдар, амьсгалын замын эмгэгийн эмчилгээнд хэрэглэгддэг 15 ерөнхий нэршлийн эмийг Швейцар Улсын “Новартис Глобал Хеалт” компанитай хамтран “Новартис Эмийн Хүртээмжийн Хөтөлбөр” -ийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сангаас 100% хөнгөлөлттэй олгохоор ажиллаж байна.

Цаашид эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсын байгууллагаар дамжуулан худалдан авах зорилгоор Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сангийн цахим каталогт байршсан 228 нэр төрлийн эм, Глобаль сангийн цахим худалдан авалтын платформ/wambo.org байршсан 163 үйлдвэрлэгчийн гепатитын эсрэг, хумхаа, сүрьеэ, ретровирусийн эсрэг 661 нэр төрлийн эм, “Ай Ди Эй” сангаас авах боломжтой Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон 500 гаруй эмийн мэдээллийг нэгтгэн гаргаж, холбогдох арга хэмжээг авч байна.

Мөн Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсын нэгдсэн худалдан авалтаар авах зохицуулалтын талаар тусгахаар ажиллаж байна.

3. Уламжлалт эмийн үйлдвэрлэлийг дэмжих, түүхий эдийг дотоодоос бэлтгэх, тарималжуулах талаар төрөөс баримталж байгаа бодлого, үзүүлж байгаа дэмжлэг, эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгох талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар:

Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх зорилгоор “Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх үндсэн чиглэл, хөтөлбөр”- ийг 1999, 2010, 2015 онуудад 3 удаа батлан хэрэгжүүлсэн. Монгол улс сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд уламжлалт эмийн үйлдвэрлэл, эмийн жорын судалгаа, нотолгоог орчин үеийн шинжлэх ухааны арга, аргачлалаар нотолж, үр дүн гарч байна. Үүний жишээ нь 2013-2021 оны хооронд уламжлалт анагаах ухааны жор судлал, эмийн ургамал, амьтан, эрдсийн гаралтай 200 гаруй түүхий эд, 60 гаруй жорын судалгаа хийгдэж Олон улсын сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл 26, эрдэм шинжилгээний илтгэл 74 хэвлэгдсэн.

Улсын хэмжээнд 1973 онд “Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн” Улсын үйлдвэрийн газар, 1990 онд “Манбадацан” ХХК-ын Манбадацан эмийн үйлдвэр, “Монг-Эм” ХХК-ын эмийн үйлдвэр, 1991 онд “Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв” ХХК-ын эмийн үйлдвэр, 2013 онд “Одь-Тан” ХХК-ын эмийн үйлдвэр, 2015 онд “Мон-Интра” ХХК-ын эмийн үйлдвэр тус тус байгуулагдаж нийт 7 уламжлалт эмийн үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна.

Эмийн чанар аюулгүй байдал, эмийн үйлдвэрийг чадавхжуулах, GMP хангах сургалт мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулснаар Армон эмийн үйлдвэр “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал” GMP-н гэрчилгээг 2021 онд авсан, бусад үйлдвэрүүд GMP-н шаардлагад тохирох барилга байгууламж, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг 2015 оноос шат дараатай хэрэгжүүлж байна. Тухайлбал Монг-Эм эмийн үйлдвэр GMP стандарт урсгалыг хангахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг барилга байгууламжид хийсэн, Мон-Интра эмийн үйлдвэрт GMP шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийхэд 89% үнэлгээ авсан.

Уламжлалт эмийн бүртгэл 2014 оноос эхэлсэн ба 7 эмийн үйлдвэрийн давхардсан тоогоор 218 нэр төрлийн, 1032 худалдааны нэршлийн уламжлалт эм бүртгэгдсэн нь Монгол улсад бүртгэлтэй эмийн 12.7% -ыг эзэлж байна.

Уламжлалт эмийн 300 гаруй түүхий эдийн 74% нь ургамлын, 15% нь эрдсийн, 11% нь амьтны гаралтай ба эдгээр түүхий эдийн 47% -ыг гадны улс орноос импортолдог. Эмийн чанар аюулгүй байдлыг хангах зорилгоор Монгол уламжлалт анагаах ухаанд хэрэглэгддэг түүхий эд, эмийн фармакопей 2017 онд Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгээс боловсруулан хэвлүүлсэн ба үүнд ургамлын 80, уламжлалт эмийн 80 фармакопей өгүүлэл багтсан. Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа уламжлалт эм, эмийн түүхий эдийн холбогдолтой нийт 317 стандарт байгаа ба Эрүүл мэндийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн А/219 тоот тушаалаар стандартад үнэлгээ хийх дэд ажлын хэсэг батлагдаж үйл ажиллагаа эхэлсэн.

Ургамал, амьтан, эрдсийн гаралтай уламжлалт эм үйлдвэрлэл, экспортлох үйл ажиллагаа нь эрүүл мэндийн салбараас гадна бусад салбарын хууль

тогтоомжуудаар зохицуулагдаж байна. (“Монгол Улсын Үндсэн хууль”, “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”, “Байгалийн ургамлын тухай хууль”, “Ургамал хамгааллын тухай хууль”, “Амьтны тухай хууль”, “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хууль”, “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль”, “Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль”, “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль”, “Ховордсон амьтан ургамал тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль”, “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль”, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”)

Дээрх хуулийн хүрээнд уламжлалт эм үйлдвэрлэгч дараах 4 үнэлгээ, аудитыг хийлгэсэн байх шаардлагатай байдаг.

1. Байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ,
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ,
3. Байгаль орчны аудит /2 жил тутамд/,
4. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ

Эдгээр үнэлгээ тус бүрийг хийлгэхэд уламжлалт эм үйлдвэрлэлээс багахан хэмжээний ашиг хардаг салбарын хувьд ихээхэн хэмжээний цаг хугацаа, санхүү ордог тул дээрх хуулийн заалтуудын нийцлийг нарийн судалж зайлшгүй шаардлагатай үнэлгээг хийлгэх нь зүйтэй гэсэн саналыг оруулсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны “Байгалийн ургамал ашиглах дээд хэмжээ тогтоох тухай” А/136 дугаар тушаалаар нийт 39 нэр төрлийн ургамлын жагсаалт болон үйлдвэрийн зориулалтаар 2021 онд түүж бэлтгэх ургамлын дээд хэмжээг баталсан. Дээрх 39 ургамлын 8 нь эм үйлдвэрлэлд шаардлагатай ургамал байгаа бөгөөд жагсаалтыг шинэчлэн батлах ажлын хэсэгт санал хүргүүлэхээр ажиллаж байна.

Ховор, нэн ховор эмийн ургамлын тарималжуулалтын хувь манай улсад төдийлөн сайн хөгжөөгүй бөгөөд үүнд дээр ХХААХҮЯ, БОАЖЯ, Ботаникийн хүрээлэн, Монголын тариаланчдын үндэсний холбоо зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

"Уламжлалт анагаах ухааны салбарын өнөөгийн байдал хэтийн төлөв, асуудал, шийдэл" сэдэвт зөвлөгөөнийг 2022 оны 5 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөж, дараах тулгамдаж буй асуудлыг хэлэлцүүлэн, оролцогч талуудын саналыг тусгахаар ажиллаж байна. Үүнд:

- Уламжлалт эмийн үйлдвэрийг төрийн бодлогоор бодитой дэмжих, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP/-ын шаардлага хангахад шаардах санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломж;
- Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/295 дугаар тушаалаар батлагдсан “Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэх журам” -ын

бүртгэлийн төлбөрийн төрөлд үндэсний үйлдвэрийн уламжлалт эмийн төлбөрийг эмийн зах зээлийн багтаамжтай нь уялдуулах;

- Дотоодын ургамлын тархац нөөцийг хамгаалах, ховор, нэн ховор ургамлыг тарималжуулахад шаардлагатай хөнгөлөлттэй зээл, эсвэл мэргэжлийн байгууллагаар тарималжуулах ажлыг гүйцэтгүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- Уламжлалт эмийн үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүнүүдийг хөнгөлөлттэй олгох эмийн жагсаалтад оруулахад боломж;
- Ургамал, амьтан, эрдсийн гаралтай эм, эмчилгээний зориулалт бүхий түүхий эдийн экспортыг хязгаарлах, гаалийн хяналтыг сайжруулах;
- Уламжлалт эмийн түүхий эдийг нэгдсэн зохион байгуулалтаар бэлтгэн авч, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэд ашиглах боломжийн талаар;
- Уламжлалт эмийн үйлдвэрүүд нэгдсэн зохион байгуулалтаар түүхий эд татан авах зохицуулалтын талаар;
- Уламжлалт эм үйлдвэрлэдэг үндэсний үйлдвэрүүдэд дотоодоос түүж бэлтгэх ургамлын зөвшөөрлийг хялбарчилсан аргаар, шуурхай шийдвэрлэх талаар;
- Дотоод, гадаад түүхий эдийн стандарт боловсруулах, Эмийн түүхий эдийг эмийн улсын бүртгэлд бүртгэх;
- Ховор, нэн ховор ургамлын нөөцийг хамгаалахад хувийн хэвшил, төрийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, хамгаалалтад авах зохицуулалт;
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас гаргадаг “Үйлдвэрийн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын дээд хэмжээ”-ний жагсаалтад үйлдвэрлэгчдийн саналыг нэмэлтээр тусгах;
- Төрийн байгууллагуудын уламжлалт эм, түүхий эдийн чиглэлээрх мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх;
- Импортоор орж ирж буй ургамлын гаралтай эм, БИБ, задгай эмэнд хөндлөнгийн болон салбарын хяналтыг сайжруулах, хязгаарлах, импортыг орлох бүтээгдэхүүнийг дэмжиж үндэсний уламжлалт эм үйлдвэрлэлийн зах зээлийг хамгаалах талаар урт хугацааны стратеги хэрэгжүүлэх чиглэлээр;
- Уламжлалт эмзүй чиглэлийн төрөлжсөн мэргэжил эзэмшсэн хүний нөөцийн дутагдалтай байгаа тул хүний нөөцийг бэлтгэх чиглэлээр;

Мөн эм, эмнэлгийн хэрэгслийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, санхүүгийн эрсдэлд орохоос сэргийлэх зорилгоор Монгол банкнаас хэрэгжүүлж буй Репо санхүүжилтийн зээлд хамрагдуулж өгөх хүсэлтийг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 1а/1403 тоот албан бичгээр Монгол банканд хүргүүлээд байна. Нийт хүсэлт гаргасан 35 байгууллагаас Уламжлалт эмийн үйлдвэр 4 байгаа бөгөөд 5,1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлт гаргасан.

4. Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр олгож буй эмийн нэр төрөл, үйлчилгээ, санхүүжилтийн хэмжээ жил бүр өсөн нэмэгдэж байгаа хэдий ч үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай зарим эмийн нэр төрлийн сонголт буруу, оновчгүй, тогтоосон үнийн дээд хязгаар, хөнгөлж байгаа хэмжээ нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн хувиасаа төлөх төлбөрийн хэмжээг дорвитой бууруулж чадахгүй байгаа тул холбогдох хууль тогтоомж, эрх зүйн орчныг

боловсронгуй болгох талаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.10 дахь заалтад “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох” гэсний дагуу Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээний жагсаалт”-ыг баталсан. Энэхүү жагсаалтыг шинэчлэх ажлын хүрээнд эмийн нэр, төрөл, худалдааны нэршил, үнийн зах зээлийн судалгаа хийж, эм тус бүрийн өртөг тооцох ажлыг зохион байгуулж байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь хөнгөлөлттэй эмийн жагсаалтыг хүн амын дунд зонхилон тохиолдох өвчин эмгэгийн эмчилгээнд хэрэглэх олон улсын эмнэлзүйн удирдамжид зөвлөсөн эмийн тун хэмжээгээр сонгож, үнийн дүнгээс хамааруулан 30, 50, 70 хувийн хөнгөлөлттэй үнээр иргэн даатгуулагчид хүргэн ажиллаж байна. Үүний дотор нас баралтын шалтгаан болж байгаа болон удаан хугацаагаар тогтмол хэрэглэдэг, даатгуулагчийг санхүүгийн эрсдэлд оруулдаг эмүүд болох зүрх судасны өвчин, уналт таталтын эсрэг эм, чихрийн шижингийн эсрэг эмүүд болон зарим вирусийн эсрэг эмэнд 70 хувийн үнийн хөнгөлөлт үзүүлж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

---oOo---